

**БНМАУ АЗИЙН ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
БЭХЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД****Ц. Пунцагноров**

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Империалист гүрнүүдийн, юуны өмнө АНУ-ын түрэмгий бодлогын уршгаар олон улсын байдал хурцдаж байгаа өнөөгийн нөхцөлд Азийн энх тайван, аюулгүй байдлын төлөө тэмцлээ улам хүчтэй болгох явдал энэ тивд оршин амьдарч байгаа бүх улс түмний ариун үүрэг мөн.

Ийм ч учраас МАХН-ын XVIII их хурал БНМАУ-ын гадаад бодлогын чиг шугамыг тодорхойлон заахдаа: «Азийн энх тайван, аюулгүй байдлыг азийн улсуудын хамтын хүч чармайлтаар бэхжүүлэхэд зүйл бүрээр тус дөхөм үзүүлэх»¹ зорилтыг дэвшүүлсэн юм.

Азийн энх тайван, аюулгүй байдлын төлөө Монголын ард түмнээс явуулж буй тэмцлийн тухай ярихдаа БНМАУ, ЗХУ-ын хооронд тогтсон ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааны олон улсын ач холбогдлыг юуны өмнө тэмдэглэвэл зохино.

Манай хоёр улс дэлхийн II дайны жилүүдэд Алс Дорнодод японы империализмын түрэмгийллийн гол замыг хааж, Хятад, Солонгос, Вьетнам болон бусад орны ард түмний эрх чөлөөний тэмцэлд бодит дэмжлэг үзүүлсэн юм. ЗХУ германы фашизмыг бут ниргэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснээрээ улс үндэстнийг арьс өнгөөр ялгаварлаж аймаглан устгах аюулаас Азийн олон орны ард түмнийг авран хамгаалсан билээ.

Монгол—Зөвлөлтийн хамтын ажиллагаанд анх биелэлээ олсон улс бүхний бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, том бага үндэстний тэгш эрхийг хүндэтгэх үзэл санаа, зарчмыг одоо дэлхий нийтээр хүлээн зөвшөөрчээ.

Монгол—Зөвлөлтийн хамтын ажиллагааны туршлага нь эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө улс түмний тэмцлийн эрх зүйн үндсийг батжуулахад тус дөхөм үзүүлж олон улсын харилцааг зарчмын шинэ үндсэн дээр өөрчлөн байгуулахад жинтэй хувь нэмэр оруулсан юм. Монгол—Зөвлөлтийн хамтын ажиллагаа нь далайц, үр бүтээлийн хувьд Азийн орнуудын түүхэнд хосгүй үзэгдэл юм.

¹ Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт. 24-р тал.

Пролетарийн интернационализмын заримд тулгуурласан ийм хамтын ажиллагаа анх үүссэн цагаасаа эхлэн Азийн энх тайван аюулгүй байдлын нэн чухал хүчин зүйл болсоор ирсэн билээ.

МАХН, БНМАУ-ын засгийн газар өөрийн орны болон Ази, Алс Дорнодын аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд Хятадын милитаристууд, харгис гоминданыхны түрэмгий өнгөлзлөгийг няцааж Хятад улстай хөрш айлын хэвийн харилцаа тогтоох бодлогыг тууштай явуулж ирсэн юм.

Хятад оронд ардын хувьсгал ялснаар хоёр улсын харилцаанд цоо шинэ үе эхлэнэ гэж Монголын ард түмэн үнэнхүү найдаж байсан юм. Гэтэл Хятадын маоист удирдлага маркизм-ленинизм, пролетарийн интернационализмд дайсагнасан байр суурь баримтлах болсноос хойш монгол-хятадын харилцаа эрс муудсан билээ. Уг харилцаа ийнхүү муудсаны шалтгаан бол Хятадын эрх баригчдаас их гүрний жанжлах бодлого явуулж манай орныг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг оролдож байгаад оршино гэж МАХН-ын XVIII их хурал тэмдэглэжээ.

Сүүлийн үед БНХАУ-д маоизмын нэгэнт нэр хүндгүй болсон зарим үзэл баримтлалыг буруушааж Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг хүндэтгэн бусдын дотоод хэрэгт оролцохгүй гэх зэргээр тунхаглах боллоо. Гэтэл Бээжингийн удирдагчид, тунхагласан зарчмаа бүдүүлгээр зөрчсөөр байна. Жишээ нь Хятадын удирдагчид ЗХУ-тай харилцаагаа хэвийн болгох үндсэн нэг болзол болгож манай засгийн газрын хүсэлтээр, найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах гэрээний дагуу БНМАУ-д байрласан зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах шаардлага тавьж байгаа юм. Ах дүү орны цэргийг урьж өөрийн нутаг дэвсгэр дээр байрлуулах буюу гаргах нь НҮБ-ын дүрмийн ёсоор БНМАУ-ын дотоод хэрэг, бүрэн эрх нь юм. Иймээс Хятадын шаардлага бол манай улсын дотоод хэрэгт оролцох гэсэн оролдлого даруй мөн. Үүнтэй холбогдуулан БНМАУ-ын засгийн газраас 1978 оны 4 дүгээр сарын 12-нд Хятадын засгийн газарт илгээсэн нот бичгийг эргэн саная Уг нотод:

«...БНМАУ-аас зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах тухай асуудал гагцхүү тэднийг ирүүлэх болсон шалтгааныг арилсан цагт л яригдаж болох нь тодорхой байна. Хэрэв Хятадын удирдлага, БНМАУ-ыг эзлэн дагуулах бодлогоо эгнэгт орхиж, БНМАУ, ЗХУ-тай сайн хөршийн ёсоор харилцаж хамтран ажиллах замд орвол зөвлөлтийн цэргийг БНМАУ-д байлгах шаардлага аяндаа үгүй болох юм»³ гэжээ.

БНМАУ-ын засгийн газрын 1984 оны 3-р сарын 2-ны мэдэгдэлд «БНМАУ-ын нутагт зөвлөлтийн цэргийн ангиуд байрлаж байгаа нь БНХАУ, ЗСБНХУ-ын харилцааг хэвийн болгоход ямар нэг саад тотгор учруулж байна гэж үзэж болохгүй» гэдгийг тэмдэглэхийн хамт манай улсын урьд жилүүдэд хамтран гаргасан Монгол—Хятадын хэд хэдэн баримт бичигт нотлон заасан зарчмын үндсэн дээр хоёр орны хооронд сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаагаа сэргээн хөгжүүлэхийн төлөө байгааг цохон дурджээ.⁴

Хятадтай харилцаагаа хэвийн болгох талаар дэвшүүлсэн Зөвлөлт засгийн газрын удаа дараагийн ажил хэрэгч санал, санаачилгыг БНМАУ байнга сайшаан дэмжиж ирлээ.

³ «Үнэн» 1983 оны 4-р сарын 17, № 92.

⁴ «Үнэн» 1984 оны 3-р сарын 3, № 54 (15703)

Харин хятадтай харилцаагаа сайжруулахдаа өөрийн анд нөхөр холбоотны аюулгүй байдалд хохирол учруулахгүй гэдгийг ЗХУ дэлхий нийтэд мэдэгдсэн юм. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нөхөр К. У. Черненко Москва хотын Куибышевын районы сонгогчдын өмнө хэлсэн үгэндээ: «Бид уг харилцааг ингэж хэвийн болгохын төлөө тууштай тэмцэж байна. Гэтэл зарчмын нэлээд хэдэн асуудлаар санал зөрөлдөөнтэй хэвээр байгааг улс төрийн зөвлөлдөөн харууллаа. Тухайлбал бид гурав дахь улс орныг хохироох замаар хэлэлцэн тохирохыг зөвшөөрөхгүй гэж тов тодорхой заан тэмдэглэжээ.⁵

Сүүлийн үед Зөвлөлт—Хятадын харилцаанд зарим нааштай хандлага гарч байна. Тухайлбал, тусгай төлөөлөгчдийн хэмжээнд улс төрийн зөвлөлдөөн үргэлжилж худалдааны хэмжээ өсөн, шинжлэх ухаан-техник, соёл спортын харилцаа өргөжиж байна. ЗХУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болох нь зөвхөн энэ хоёр орны ард түмний ашиг тусад төдийгүй «улмаар Ази Тив, даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт нийцэхсэн билээ» гэж МАХН-ын ТХ-ны VII бүгд хурал (1983) тэмдэглэв.⁶

Монгол—Хятад, Зөвлөлт—Хятадын харилцаа цаашид хэрхэн хөгжиж хэдийд хэвийн байдалд орох нь Хятад улсаас л шалтгаална. АНУ тэргүүтэй империалист хүчний цөмийн зэвсгээр хөөцөлдөх адал балмад явууллагын улмаас олон улсын харилцаанд бий болсон өнөөгийн туйлын аюултай нөхцөлд Хятад нь ЗХУ, Азийн социалист орны талаар АНУ, империалист бусад гүрнүүдтэй нэг чигийн зэрэгцээ бодлого явуулж байна.

Стратегийн судалгааны Вашингтоны төвөөс 1979 онд бэлтгэсэн «Зүүн умард Азийн стратеги, аюулгүй байдал» гэсэн эмхтгэлд: «Хятад нь Япон, АНУ-тай холбоо тогтоож ЗХУ-ын эсрэг байр сууриа хүчтэй болгохыг эрмэлзэж байна», энэхүү зорилтоос үндэслэн Хятадууд Өмнөд Солонгост АНУ-ын цэрэг байрлаж байгаад талархаж «Нэн ялангуяа хуурай газрын цэрэг, цөмийн пуужин байгуулахыг сайшааж байна» гэж бичжээ.⁷

ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан 1983 оны 11-р сард Японд айлчлахдаа «ЗХУ-ын аюул занал» гэсэн улигт гүтгэлгийг давтаж ЗХУ-тай харилцааг хэвийн болгоход оршиж буй «гурван саад» гэгчийг дахин сөхснөөс гадна Ху Яобаныг дагалдан явсан Хятадын гадаад явдлын яамны сайд Ү Сюецянь ЗХУ-ын Курилын дөрвөн аралд санаархсан Японы өнгөлзлөгийг дэмжсэн үг Саппоро хотод хэлжээ.

Хятад нь Зүүн Өмнөд Азид түгшүүртэй байдлыг дэвэргэж БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын талаар эзлэн түрэмгийлэх бодлого явуулан тэднийг АСЕАН-ы орнуудтай халз мөргөлдүүлэхийг оролдож мөн АНУ, Пакистантай хамтран БНААфГУ-ын эсрэг зарлаагүй дайн явуулж байгааг элдвээр дэмжсээр байна.

1983 онд Хятад, АНУ хоёр эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл, цөмийн болон цэргийн талаар хатын ажиллагаагаа өргөжүүлжээ. 1983 оны 2-р сард АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Шульц Бээжинд айлчилсанаас хойш Америк-Хятадын харилцаанд «ихээхэн ахиц» гарлаа гэж хоёр тал нэгэн дуугаар цохон тэмдэглэжээ.

Европт америкийн дунд зайны цөмийн пуужинг байрлуулж эхэлсэнтэй холбогдож олон улсын байдал үлэмж хурцадмал үед БНХАУ-

⁵ «Үнэн» 1984 оны 3-р сарын 4.

⁶ МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал. УБ. 1983. 15-р тал.

⁷ Strategy and security in Northeast Asia. Strategic Studies Center, N. Y. 1979. p. 58, 86.

ын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Чжао Цзыян Вашингтонд айлчилсныг тэмдэглэх хэрэгтэй. Айлчлалтын үеэр Хятад, АНУ-ын хооронд үйлдвэр-техник, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулж цөмийн талаар хамтран ажиллах хэлэлцээрийг бэлтгэх ажлыг түргэвчилжээ. Эдгээр хэлэлцээр Хятадын эдийн засагт америкийн хөрөнгө оруулалтыг үлэмжхэн нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр Хятад, АНУ-ын хооронд цэргийн хамтын ажиллагаа өргөжих төлөвтэй байна. АНУ-аас цэргийн зориулалттай хамгийн сүүлийн үеийн технологийг хятадад шилжүүлэх явдал Хятад—Америкийн цэрэг-стратегийн хамтын ажиллагааны суурь дэвсгэр болж болох юм.

АНУ-ын засаг захиргаа нь америк, хятадын өндөр тушаалын хүмүүсийн айлчлалыг зөвлөлт-хятадын харилцааг хэвийн болгоход, саад хийхэд ашиглаж БНХАУ-ын гадаад бодлогын зөвлөлийн эсрэг агуулгыг өөгшүүлэн дэмжихийг эрмэлзэж байгааг энэ оны 4-р сард АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейганы Хятадад хийсэн айлчлалт бас дахин гэрчлэв.

Рейганы айлчлалын гол зорилт нь ЗХУ, социалист орнуудын эсрэг чиглэсэн америк-хятадын стратегийн хамтын ажиллагааг өргөтгөх, Хятадын эдийн засагт АНУ-ын капиталист монополиудын нөлөөг хүчтэй болгох, цэрэг-эдийн засгийн потенциалыг нь бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд оршиж байв. Рейган Бээжинд байхдаа ЗХУ-тай халз мөргөлдөхийг уриалж Хятадыг социалист орнуудын эсрэг «Загалмайтны аян дайнд» татан оруулахыг илэрхийгээр оролдов.

АНУ-Хятадын энэ удаагийн хэлэлцээр юу харуулав? Хятадын тал гол зөрөлдөөнтэй Тайваний асуудлыг хурцатгахгүй, АНУ-тай санал нийлж буй асуудлаар хэлэлцэн тохиролцохыг урьдал болгосон байна. Хятадын эрх баригчид зэвсэглэлээр хөөцөлдөх, Японы милитаризмыг сэргээх, Алс Дорнодод АНУ, Япон, Өмнөд Солонгосыг оролцуулан цэргийн эвсэл байгуулах гэх зэрэг зангилаа асуудлаар АНУ-ын засаг захиргааны бодлогыг чухамдаа дэмжив. Түүнчлэн Вьетнам, Лаос, Кампучи болон Афганистаны эсрэг явуулах ажиллагааны талаар АНУ, Хятад хоёр нэг чиг баримталж байна. Рейганы Бээжинд айлчлах үеэр Хятадын цэрэг Вьетнамын хил хязгаарт зэвсэгт өдөөн хатгалгаа идэвхжүүлсэн нь тохиолдлын хэрэг биш ээ.

Бээжингийн эрх баригчид хэлэлцээрийн үеэр Хятад—Зөвлөлтийн харилцааны тухай ярихдаа БНМАУ, Азийн социалист бусад орны дотоод хэрэгт оролцож «гурван том саад» гэгчийг зайлуулах шаардлагыг давтсан болно.

Хэлэлцээрийн явцад АНУ, Хятад хоёр эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын болон цөмийн талаар хамтын ажиллагааг өргөтгөхөөр тохиров. Мөн америкийн зэвсэг худалдах тухай асуудал хэлэлцэж тодорхой зүйлээр тохиролцохын тулд энэ оны 6-р сард Хятадын батлан хамгаалах яамны сайдыг АНУ-д айлчлуулахаар болсон нь анхаарал татаж байна. Хятадын тал танк, нисэх онгоц, эсэргүүцэх пуужин, техник хэрэгслийг америкийн лицензээр үйлдвэрлэх тухай хэлэлцээр хийж «Ф—16» хэмээх шинэхэн сөнөөгч бөмбөгдөгч нисэх онгоц худалдан авахыг сонирхож байгаа тухай гадаадын хэвлэлд бичиж байна.

Хятад АНУ-ын хооронд цэргийн хамтын ажиллагаа гүнзгийрч байгаа нь Азийн зарим орныг түгшүүлж байна. Малайзын ерөнхий сайд Махаткор Бин Мохаммед америк-хятадын цэргийн хамтын ажиллагаа өргөжиж байгаатай холбогдуулан хэлэхдээ: «Хэрэв Хятад орчин цагийн довтлох зэвсэг авах юм бол өөрийн хил хязгаараас гадагш цэргийн аюултай балмад ажиллагаа явуулж болзошгүй юм»⁸ гэжээ.

⁸ «Новости Монголии» 17 января 1984, № 5.

АНУ нь Хятадтай харилцаагаа өргөтгөхдөө стратегийн нийтлэг зорилтын үүднээс хандаж байна. «Правда» сонин Хятад—Америкийн харилцааны сүүлийн үеийн байдлын тухай бичихдээ: «АНУ-ын эрх баригч бүлгийнхний хүч чармайлт юуны өмнө Вашингтоныхны дэлхийг хамарсан зөвлөлтийн эсрэг чиг шугамд Хятадыг хамруулж империализмын ашиг сонирхолд нийцсэн «стратегийн түншлэлд» татан оруулах зорилготой юм.»⁹ гэжээ.

Рейганы засаг захиргаа «хятадын хүчин зүйл» гэгчийг Зүүн Ази, Номхон далайн районд олон улсын байдлыг хурцатгах, Азид АНУ-ын байр суурийг бэхжүүлэх, ЗХУ, социалист бусад орны эсрэг, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг чиглэсэн өөрийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд ашиглахыг эрмэлзэж байгаа нь илэрхий байна.

Хятадын эрх баригчид ЗХУ, БНМАУ-ын хилийн дагуу зэвсэгт хүчнийхээ тэн хагасаас илүүг хуримтлуулан манай хоёр улсад шууд заналхийлж империализмын түрэмгий ажиллагаанд тус дөхөм үзүүлж байна.

Бээжингийн жанжирхах бодлогын нэг илрэл нь Азийн олон орны газар нутагт өнгөлзөж байгаа явдал мөн. Хятадын булаан эзлэх газар нутгийн дансанд хил нийлсэн буюу ойролцоо орших улс төдийгүй алслагдсан орон ч орсон байна.

Ийм ч учраас БНМАУ нь Хятадтай харилцаагаа хэвийн болгох чиг шугам баримтлахын зэрэгцээ Бээжингийн их гүрний жанжирхах бодлогын эсрэг шийдвэртэй тэмцэж байна.

Одоо үед дэлхийн II дайн өдөөгчдийн нэг байсан Япон улсад милитаризмыг дахин сэргэж байгаа нь Азийн улс түмэн, түүний дотор Монголын ард түмний сэтгэлийг зүй ёсоор түгшүүлж байна. Монголын эсрэг чиглэсэн японы империализмын түрэмгий явууллага ХХ зууны эхэн үеэс аваад олон жил үргэлжилсэн түүхтэй юм. Японы цэрэг 1939 оны Халхын голын районд БНМАУ-ыг дайран довтолсон нь чухамдаа японы империализмаас БНМАУ, ЗХУ-ын эсрэг явуулсан зарлаагүй дайн байсан юм. Энэ дайны үеэр Японы цэргийн эрхтнүүд БНМАУ, ЗХУ-ын эсрэг бактериологийн зэвсэг хэрэглэснийг хэлэх хэрэгтэй.

30-аад оны дундуур Японы жанжин штаб болон цэргийн яамнаас Зүүн хойт Хятадын (Манжуурын) нутагт хожим 731-р отряд гэж нэрлэгдсэн маш нууц цэргийн анги байгуулжээ. Энэхүү отрядын үүрэг зорилгын тухай японы Квантуны армийн ерөнхий командлагч генерал Ямада японы цэргийн гэмт хэрэгтний хэргийг шүүсэн Токиогийн таслан шийтгэх хуралд мэдүүлэг өгөхдөө: «731-р отрядыг гол нь ЗХУ-ын эсрэг, мөн түүнчлэн БНМАУ-ын эсрэг бактериологийн дайнд бэлтгэх зорилгоор байгуулсан юм»¹⁰ гэжээ.

Японы милитаризм ялагдсаны дараа 731-р отрядын гэмт хэрэгтнүүд америкийн цэргийн командлалын ивээлээр хариуцлагаас мултарч бактериологийн зэвсгийн талаар хийж байсан ажлаа АНУ-ын лабораторид үргэлжлүүлжээ.

Халхын голын түүхэн ялалт болон Зөвлөлт—Монголын зэвсэгт хүчин 1945 онд Японы Квантуны армийг бут ниргэсэн явдал нь японы булаан эзлэгчдийн ялт ажиллагааг тас цохиж Ази тивд дэлхийн II дайны түймрийг унтраахад жинтэй хувь гэмэр оруулсан юм.

⁹ «Үнэн», 1984 оны 1-р сарын 22, № 19.

¹⁰ Материалы судебного процесса по делу бывших военнослужащих японской армии, обвиняемых в подготовке и применении бактериологического оружия. М., 1950, с. 9.

Гэвч түүхийн сургамжийг мартаж болохгүй. Японы милитаристуудаас хийж байсан бактериологийн дайны бэлтгэлийг өнөөдрийн АНУ, НАТО-гийн орнуудад үргэлжлүүлж байна.

Азийн олон орны эсрэг, түүний дотор манай улсын эсрэг хүнлэг ёсноос гадуур жигшүүрт гэмт хэрэг үйлдсэн японы милитаризм АНУ-ын дэмжлэгтэйгээр дахин өндийн босч байна.

Ази тив, Номхон далайн сав газарт америкийн империализмын явуулж буй түрэмгий бодлогын гол түшиг тулгуур болсон Японы нутаг дэвсгэр дээр одоо америкийн 46 мянган цэрэг байрлаж АНУ-ын 100 гаруй цэргийн бааз, бусад барилга байгууламж оршиж байна. «Өөрийгөө хамгаалах хүч» гэж нэрлэгддэг японы аримд хамгийн орчин үеийн зэвсгээр зэвсэглэсэн 300 мянга шахам хүн алба хааж далайн цэргийн хүч нь 110 гаруй байлдааны хөлөг онгоцтой болоод байна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар японы цэргийн галын хүч дэлхийн II дайны үеийн олон сая хүнтэй эзэн хааны армийн галын хүчнээс ихэд давжээ.¹¹

70-аад оны сүүл үеэс Токиогийн эрх баригчид цэрэг-стратегийн бодлогоо хянан өөрчилж Японы нутаг дэвсгэрийн гадна орших дайсанд цохилт өгөх асуудлыг анх тавьсан юм.

1982 онд АНУ-ын дэмжиж өөгшүүлсэнээр Японы өөрийгөө хамгаалах хүчний байлдах хүрээг японы арлуудаас гадагш 1000 милээр (1600 км) тогтоожээ. Японы орчин тойронгийн 100 милийн бүсэд далайн цэргийн хамтарсан ажиллагаа явуулах, Алс Дорнодод далайн олон улсын хоолойнуудыг хаах бэлтгэл хийх зорилгоор 1983 оны намар Япон, АНУ-ын далайн хүчний цэргийн сургууль хийжээ.

Дээрх баримтууд япон-америкийн «аюулгүйн гэрээ» гэгчийн түрэмгий мөн чанарыг гэрчилж байна.

Япон улс НАТО-гийн цэргийн түрэмгий эвсэлтэй хүчээ нэгтгэж эхэлсэн нь Азийн аюулгүй байдалд шууд заналхийлж байна. Япон бол хэрэг дээрээ НАТО-гийн Ази дахь жигүүр болон хувирч бас Алс Дорнод, Зүүн Өмнөд Азийн зарим улсыг элсүүлэн НАТО-гийн салбар байгууллагын суурь тавихыг оролдож байна.

АНУ, Япон, Өмнөд Солонгосыг оролцуулсан цэрэг-улс төрийн холбоо байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж байгааг АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейганы Алс Дорнодод 1983 оны 11-р сард хийсэн айлчлал харуулав. АНУ-ын Батлан хамгаалах яам Японд цөмийн далавчит пуужин байрлуулахад тохиромжтой гэж үзэж байна.

Энэ бүхэн японы милитаризмыг сэргээх бодлогыг эсэргүүцсэн тэмцлийг хүчтэй болгож, империалист хүчний түрэмгий явууллагын талаар байнгын сонор сэрэмжтэй байхыг Азийн орнуудоос шаардаж байна.

Азийн энх тайван, аюулгүй байдлын шийдвэрлэх хүчин зүйл бол юуны өмнө ЗХУ, социалист бусад орны энх тайвны бодлого, тэдний ах дүүгийн хамтын ажиллагаа, батлан хамгаалах хүч чадлын бэхжилт мөн. ЗХУ болон Азийн социалист орнуудын хооронд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны гэрээний систем нь империализм, жанжлалын түрэмгий хүчний ажиллагааг хазаарлан, намжмал байдлын төлөө тэмцэх үндсийг бүрдүүлж байна.

Азийн энх тайвны төлөө тэмцэлд ЗХУ онцгой чухал үүрэг гүйцэтгэж байна. Олон улсын байдлыг эрүүлжүүлэхэд чиглэсэн ЗХУКН-ын XXVI их хурлын далайцтай, иж бүрэн санаачлагууд нь Азийн аюулгүй байдлыг хангах бодит замыг зааж байгаа юм. ЗХУ нь Алс Дорнодод харилцан итгэлцэх арга хэмжээний тухай сонирхож буй бүх

¹¹ «Проблемы Дальнего Востока», 1981, № 4, с. 8.

оронтой тодорхой хэмжээгээр хийхэд бэлэн байгаагаар илэрхийлсэн нь асар их ач холбогдолтой юм.

БНМАУ Азийн социалист бусад орноос империализм, түрэмгий хүчний эсрэг явуулж байгаа тэмцлийг дэмжиж байна. Тухайлбал, өөрийн орны гаднын ямар ч оролцоогүйгээр энх тайвнаар нэгтгэх гэсэн БНАСАУ-ын чармайлтыг манай улс дэмжихийн хамт Өмнөд Солонгосыг Азийн социалист орнуудын эсрэг чиглэсэн цөмийн зэвсгийн түшиц газар болсон гэсэн АНУ-ын бодлогыг эсэргүүцэж байна.

Өмөнд Солонгост Сеулын дэглэмийн 600 мянган цэрэг, АНУ-ын цэргийн 30 бааз цөмийн зэвсэгтэй 40 мянган цэргээс гадна америкийн дунд тусгалын шинэ пужин, нейтроны зэвсэг байрлуулах гэж байгаа нь Азийн социалист орнуудад аюул занал учруулж байна.

Империалистууд болон жанжлагчдаас Зүүн Өмнөд Азийн социалист орнуудын эсрэг дайсагнасан бодлого явуулж байгаагийн уршгаар энэ районы байдал бас түгшүүртэй байна. Ийм үед Зүүн Өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны бүс нутаг болгон хувиргах, тус районы асуудлыг гадны оролцолгоогүй хэлэлцээний замаар шийдвэрлэх, үүний тулд Энэтхэг-Хятадын гурван орон, АСЕАН-ы орнуудын бүсийн зөвлөлгөөн хийх тухай БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-аас дэвшүүлсэн саналыг манай улс дэмжиж байгаа юм. Мөн түүнчлэн Монголын ард түмэн өөрийнхөө хувь заяаг өөрөө шийдвэрлэхийн төлөө империалист, харгис хүчинтэй тэмцэж байгаа БНААФГУ-тай эв санааны нэгдэлтэй байж Дундат Дорно дахины байдлыг намжаахад чиглэсэн түүний хүчин чармайлтыг сайшааж байна.

Манай улс Ази тивийн янз бүрийн оронтой улс төрийн болон соёлын хатилцаа хөгжүүлж нэлээдтэй нь тус тивийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хангах асуудлаар санал бодлоо тогтмол солилцож байна»¹²

Зөвхөн сүүлийн хэдэн жилд манай улсын албан ёсны төлөөлөгчид Энэтхэг, Балба, Бирм, Индонез, Малайз, Сингапур, Шри-Ланка, Бангладеш, Япон гэх зэрэг олон оронд айлчилж Азийн аюулгүй байдлын асуудлаар санал бодлоо солилцсон юм.

БНМАУ Азийн томоохон орон- Энэтхэг улстай уламжлалт сайн харилцаатай байдаг. Монгол—Энэтхэгийн харилцааны туршлага нь нийгмийн өөр өөр байгуулалтай Азийн улсууд энх тайвны үйлсийг бэхжүүлэх талаар үр бүтээлтэй хамтран ажиллаж болохыг нотолж байгаа юм. Энэтхэгийн энх тайванч гадаад бодлого ялангуяа ЗХУ-тай тогтоосон найрамдалт харилцаа нь Ази тивийн нийт байдалд нааштай нөлөө үзүүлж байна.

Азид бат энх тайвныг тогтоохын тулд Израилийн түрэмгийллийн улмаас Ойрхи Дорнодод үүссэн хямралыг арилгах нь чухал байна. Үүний тулд Израилийн цэргийг 1967 онд эзэлсэн бүх нутгаас гаргаж Палестины араб ард түмэнд тусгаар тогтносон улсаа байгуулах хүртэл өөрийгөө тохинуулах эрхий нь эдлүүлэх ёстой гэж манай улс үздэг юм. Энэ үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ын төлөөлөгчид Ойрхи Дорнодын асуудлыг НҮБ-д хэлэлцэхэд идэвхтэй оролцож ирэв.

Ази болон дэлхий дахины аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын үүрэг их юм. НҮБ нь манай улсын санаачилгаар олон улсын хурцадмал байдлыг намжаах, зэвсэглэлийн хойноос хөөцөлдөх явдлыг зогсоох, зэвсэг хураахын төлөө тэмцлийг идэвхжүүлэх, хөгжиж байгаа орнуудын нийгэм-эдийн засаг, соёлын дэвшлийг түргэтгэхэд чиглэгдсэн хэд хэдэн чухал тогтоол гаргасан юм. Жишээ нь

¹² Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан НТХ-ны тайлан... УБ., 1981. 22-р тал.

1978 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулган БНМАУ-ын саналаар «Зэвсэг хураахад тус дөхөм үзүүлэх олон улсын долоо хоног»-ийг жил бүрийн 10-р сард зохион байгуулж байхаар тогтсон нь Азид дайны эсрэг хөдөлгөөн өрнүүлэхэд түлхэц болов.

БНМАУ-ын олон нийт Азийг тогтвортой энх тайван, бүх талын хамтын ажиллагааны тив болгохын төлөө энхийг эрхэмлэгч хүчний хөдөлгөөнд идэвхтэй оролцож энэ чиглэлээр Дэлхийн энх тайвны зөвлөл, Ази Африкийн эв санааны нэгдлийн байгууллагаас гаргаж байгаа хүчин чармайлтанд өөрийн хувь нэмрийг оруулсаар байна.

Азийн энх тайман, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө тэмцлийг өрнүүлэхэд 1976 оны аравдугаар сард Улаанбаатарт болсон энхийг эрхэмлэгчдийн Азийн бага хурал доритой нөлөө үзүүлсэн юм. Бага хурлаас гаргасан «Улаанбаатарын тунхаглал»-д улс хоорондын харилцаанд хүч хэрэглэх, олон улсын мөргөлдөөнийг энх тайвны аргаар зохицуулан шийдвэрлэх үндсэн дээр, Азийн бүх улсын хамтын хүч чармайлтаар л Ази тивд бат энх тайван, аюулгүй байдлыг тогтоож болох юм гэж цохон тэмдэглэжээ.

Варшавын гэрээнд оролцогч улсуудын Улс төрийн зөвлөлдөх хорооны 1983 оны эхээр Прагад болсон зөвлөлтөөнөөс нийгмийн өөр өөр байгуулалтай улс орон зэрэгцэн оршиж тэгш эрх, харилцан адилхан аюулгүй байдлыг хангах үндсэн дээр нийт хүн төрөлхтний сэтгэлийг догдлуулж байгаа зангилаа асуудлыг шийдвэрлэх арга замын тухай шинжлэх ухааны үндэстэй иж бүрэн санал дэвшүүлсэн нь олон улсын асар их ач холбогдолтой юм.

Прагийн улс төрийн тунхаглалын тодорхой санаачлага, саналууд нь, тухайлбал Варшавын гэрээ, НАТО-д оролцогч улсын хооронд цэргийн хүч харилцан хэрэглэхгүй энх тайвны харилцаатай байх тухай гэрээ байгуулах санааг Ази тивийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд бүрэн хэрэглэж болох юм.

Цөмийн дайны бодитой аюул занал тулгараад байгаа одоо үед Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэх явдал нийгэм-эдийн засгийн байгууллын ялгаа, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоог үл харгалзан Азийн бүх улсын нийтийн зорилт болох ёстой. Энэ зорилтыг биелүүлэх болон Азийн улс түмний хооронд харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс МАХН-ын XVIII их хурлаас тодорхой санаачилга гаргасан юм.

МАХН-ын XVIII их хурлын тайлан илтгэлд «Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулаж байх саналыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс дэвшүүлж байна. Энэ зорилгоор эдгээр бүс нутгийн улс орны бага хурлыг хуралдуулж НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн бүх орныг урьж оролцуулж болох юм»¹³ гэжээ.

БНМАУ-ын саналын гол зорилт бол нийгэм-эдийн засгийн өөр өөр байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших үзэл санааг амьдралд хэрэгжүүлэн Ази, Номхон далайн районы улс хоорондын харилцаанд түрэмгийлэл, хүч хэрэглэх явдлыг гаргуулахгүй байх нөхцөлийг бий болгоход тус дөхөм үзүүлэх явдал мөн.

¹³ Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт. УБ., 1981, 24-р тал.

Манай улсын энэ санал энх тайвнаар зэрэгцэн орших, хүч үл хэрэглэхийн төлөө улс түмний хамтын чармайлтын үзэл санаанд тулгуурлаж Азийн эвсэлд нэгдээгүй нийт улсаас сайшаасан Бандунгийн зарчимтай уялдаж байна.

БНМАУ-ын энх тайванч санаачилга чухамдаа Азийн бүх улс үндэстний амин чухал эрх ашгийг илэрхийлж байгаа юм.

БНМАУ-ын санаачилга энх тайвныг хамтын хүчээр хамгаалах үзэл баримтлалыг үндэслэж байгаа юм. Учир нь Азийн бүх улсын хүчийг энх тайвны үйлст нэгтгэх замаар л дайн, цөмийн дайны аюултай амжилттай тэмцэж нийгмийн өөр өөр байгуулалтай улсуудын хооронд үр бүтээлтэй хамтын ажиллагааг тогтоож чадна.

Янз бүрийн тивийн улс орон, бүс нутгийн хүрээнд энх тайвнаар үр нөлөөтэй хамтран ажиллаж болохыг олон улсын харилцааны туршлага гэрчилж байна. Тив тивийн буюу тивийн доторхи салбар бүсээс улс түмний энх тайвныг сахих дэлхий дахины систем бүрэлдэн тогтох ёстой.

Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, цэрэг-эдийн засгийн хүч чадал, нийгмийн байгууллыг үл харгалзан бүх улсад тэгш эрх, адилхан аюулгүй байдлыг хангах явдал бүс нутгийн аюулгүйн систем оршин тогтнох нэн чухал нөхцөл мөн.

Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулахтай холбогдсон тодорхой асуудлыг манай улсын гаргасан саналын дагуу Азийн болон Австрали, Шинэ Зеландийг оролцуулан Номхон далай бүх орны бага хурлаар хэлэлцэн тохирч болох юм. НҮБ-ын дүрмээр олон улсын аюулгүй байдлыг сахихад онцгой хариуцлага хүлээсэн Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүд уг бага хуралд оролцож конвенцээр авах үүргийн биелэлтэнд зохих баталгаа өгөх нь чухал байна.

БНМАУ-ын санаачилга Азийн улс хоорондын харилцаанд итгэлцэл, энх тайвны төлөө хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн бусад орны санал бодол, өргөн олон нийтийн хүсэл мөрөөдөлтэй нийцэж байгаа учир манай тивийн янз бүрийн улсын сайшаал, дэмжлэгийг хүлээжээ.

Азийн социалист орны удирдагчид манай улсын санаачилгыг хэрэгжүүлэхэд бүхий л аргаар туслан дэмжихэд бэлэн байгаагаа илэрхийлжээ. Эвсэлд нэгдээгүй нэлээд орны засгийн газар БНМАУ-ын саналыг нааштай үнэлж зарим улс конвенц байгуулах хэлэлцээр хийвэл оролцоно гэж мэдэгджээ.

БНМАУ-ын санаачилга нийт хүн төрөлхтөний хүсэл мөрөөдлийг илэрхийлж байна гэж НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга захидалдаа тэмдэглэжээ.

Азийн орны дэвшилт олон нийт манай улсын саналыг халуунаар сайшааж байна.

34 улс, олон нийтийн арваад байгууллага оролцож 1983 оны дөрөвдүгээр сард Улаанбаатарт хуралдсан Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурал Ази тивд ноцтой аюул занал тулгараад байгаа өнөө үед БНМАУ-ын санал асар их ач холбогдолтой болж байна гэж онцлон тэмдэглэжээ.¹⁴

Дэлхийн энх тайвны зөвлөлийн ерөнхийлөгч Ромеш Чандра хэлсэн үгэндээ: «БНМАУ энх тайвны төлөө тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн, гүйцэтгэж байна. Гүйцэтгэх болно» гэж манай орны хүчин

¹⁴ «Үнэн» 1983 оны 4-р сарын 29, № 102, 1-р нүүр

чармайлтыг үнэлээд «Ази, Номхон далайн бүх орон харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах санал нь өнөө үед энэ бүс нутаг төдийгүй, дэлхий дахины хувьд маш чухал санаачилга юм»¹⁵ гэжээ.

Бага хурлаас гаргасан Тунхаглалд Ази, Номхон далайд дайн түгшүүрийн олон голомт байгаагаас гадна АНУ пуужинт-цөмийн баазуудыг өргөжүүлж шинээр барьж Алс Дорнод болон Ойрхи Дорнодод дунд тусгалтай «Першинг-2» пуужин, далавчит пуужин, нейтроны зэвсэг байрлуулахыг санаархаж байгаа нь байдлыг улам даамжруулж байгааг тэмдэглэв.

Бүсийн бага хурлын Тунхаглалд зэвсгээр хөөцөлдөхийг зогсоох, цөмийн сүйрлийн аюулыг сэрэмжлэн зайлуулахын төлөө тэмцлээ идэвхжүүлэн Ази дахь дайн түгшүүртэй байдлын голомтыг устгахад бүхий л чармайлт тавьж Азийн улсуудын хоорондын харилцаанд итгэлцлийн арга хэмжээг дэлгэрүүлэх, харилцан ойлголцох уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой санаачилгыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхийг Ази, Номхон далайн орнуудын олон нийтэд уриалжээ.¹⁶

НАТО, АНЗЮС-ын цэргийн эвслийн гишүүн зарим орон, түүнчлэн Япон улс янз бүрийн шалтгаар манай орны энх тайванч санаачилгын ач холбогдлыг үгүйсгэх буюу бууруулах гэсэн оролдлого хийж байна.

Ази тивд мөргөлдөөний голомт унтраагүй нөхцөлд хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах нь бодитой зүйл биш гэж манай улсын саналыг эсэргүүцэгчид үзэж байна. БНМАУ-ын саналаар бол дэлбэрэх аюултай чухамхүү тийм голомт байгаа нь Ази дахины хамтын хүчин чармайлт гаргахыг шаардаж байна.

Конвенц байгуулах нь НҮБ-ын дүрэмд нэгэнт тусгасан үүргийг зөвхөн давтахад хүрнэ гэдэг ч хүмүүс бий. Гэтэл олон улсын практикаас үзэхэд НҮБ-ын дүрмийн ерөнхий үндслэлийг дэлхийн аль нэг бүс нутгийн онцлогтой холбож тодруулах нь чухал байдаг. НҮБ-ын дүрмийн 52-р зүйлд энх тайван, аюулгүй байдлыг сахих асуудлаар бүсийн хэлэлцээр байгуулж болохыг заажээ.

Бүхэл бүтэн тивийн улсуудаас хүч үл хэрэглэх үүргийг хууль зүйн үүднээс нотлон бататгавал НҮБ-ын дүрмийн үр нөлөөг нэмэгдүүлж олон улсын энэхүү чухал байгууллагын нэр хүндийг улам дээшлүүлэх болно.

Империализм, милитаризм, жанжлалын эсрэг Ази тивд бат энх тайвныг тогтоохын төлөө БНМАУ-ын явуулж ирсэн, явуулж байгаа шаргуу тэмцэл, тууштай хүчин чармайлт нь манай улсын ленинч гадаад бодлогын интернационалч шинж чанар, энхийг эрхэмлэсэн Монголын ард түмний зориг санааг илэрхийлж байгаа юм.

¹⁵ «Үнэн» 1983 оны 4-р сарын 27. № 100, 1-р нүүр

¹⁶ «Үнэн» 1983 оны 4-р сарын 29. № 102, 1-р нүүр

МНР В БОРЬБЕ ЗА УКРЕПЛЕНИЕ МИРА И БЕЗОПАСНОСТИ В АЗИИ

(Резюме)

Ц. Пунцагноров
член. корр. АН МНР

В статье члена-корреспондента Академии наук МНР Ц. Пунцагнорова освещается место и роль нашей страны в укреплении международной безопасности, в свете анализа и выводов XVIII съезда МНРП.

Автор проводит мысль о том, что государства азиатского континента, занимающего треть земной суши и где обитает более половины человечества, призваны внести весомый вклад в решение самой главной проблемы современности-предотвращение мировой термоядерной катастрофы.

На основе исторического опыта, показано международное значение монголо-советского сотрудничества как важного фактора сохранения мира в Азии и на Дальнем Востоке. Указывается, что идеи и принципы, впервые воплощенные в монголо-советском сотрудничестве, нашли широкое распространение в межгосударственных отношениях и способствовали их перестройке на принципиально новой основе. Делается вывод, что пролетарский интернационализм-надежное средство успешного решения жизненных национальных проблем и обеспечивает подлинно равноправные отношения между государствами.

В статье показываются негативные последствия политики великодержавного гегемонизма и экспансии, проводимой Пекином в отношении МНР и указывается на готовность МНР, восстановить и развивать добрососедство и сотрудничество с КНР на основе принципов, уже зафиксированных в ряде монголо-китайских документов. Автор, опираясь на конкретные факты, обосновывает позицию МНР, выступающую против возрождения японского милитаризма, показывает взаимоотношения нашей страны с другими государствами азиатского региона, ее участие во всеобщей борьбе за мир и международную безопасность. При этом подчеркивается, что система договоров о дружбе и сотрудничестве между Советским Союзом и социалистическими странами Азии сдерживает агрессивные действия империалистических и гегемонистских сил, создает надежную основу борьбы за разрядку.

Большое внимание уделено внешнеполитической инициативе МНР по укреплению доверия в отношениях между государствами Азии, выдвинутой XVII съездом МНРП.

Автор затрагивает политические и юридические аспекты предложения МНР о заключении Конвенции о взаимном ненападении и не применении силы в отношениях между государствами Азии и Тихого океана, подвергает критике т.н. «доводы» противников инициативы. По его мнению, региональная основа является действенной формой сотрудничества различных государств на основе принципов мирного сосуществования. Именно из региональных и субрегиональных зон безопасности должна сложиться всемирная система поддержания мира между народами. Выражается убеждение, что заключение региональной общеазиатской Конвенции будет способствовать выработке коллективного подхода к решению узловых международных проблем.